



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2018 оны 02 дугаар сарын 27

№ 01/У/ ДУА-2018/29/СТА -ТЦЗ Мандалговь хот

Г

Т

Төлбөр барагдуулах тухай

Аймгийн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Соёлын төвийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар тайзны шимтгэлийн **60,000.00 /Жаран мянган/ төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн зөрчил илэрлээ.**

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.3-д /Татварын бус орлого нь төрийн болон орон нутгийн өмчт, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн болон орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, төрийн болон орон нутгийн өмчийн эд хоронгийг ашигласны төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийг түрээслэсний орлого, тorgуулийн орлого, төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлого, Засгийн газрын зээллэг, тусlamж болон хууль тогтоомжийн дагуу тосвөт төвлөрүүлэх бусад орлогоос бүрдэнэ./, Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ын 2.6-д /тосвийн байгууллага улдсэн болон туслах үйл ажиллагаанаас орох орлогыг монгол касстай бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /туүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн одорт багтаан кассын нярав төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана./, аймгийн Засаг даргын 2009 оны 97 дугаар захирамжаар батлагдсан “Үнэт цаас, тасалбарын маягт хэвлүүлэх, бүртгэх, зарцуулах журам”-ын 3.6-д /Төлбөрт үйлчилгээ, хураамж хураах тухай бүр хариуцсан ажилтанд үнэт цаас, тасалбарын маягтыг актаар хүлээлгэн огч орсон орлого, зарцуулалтын тайланг тогтолц болон төлбөрт үйлчилгээ үзүүлсний дараах ажлын 1 одрийн дотор гаргуулан тооцоо бодож, орлогыг байгууллагын дансанд тушаалгаж байна/ гэж заасныг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3.1.1-д /Улсын болон орон нутгийн төсөв, Засгийн газрын тусгай сан, хөтөлбөр, биеэ даасан эрхийн актаар зохицуулагддаг сан хөтөлбөр батлагдсан төлөвлөгөөнд тусгагдсан

орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй/ гэсэн заалтуудыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Тайзны шимтгэлийн орлогын 60,000.00 /Жаран мянган/ төгрөгийг эрхлэгч М.Ганбудаар нөхөн төлүүлж, Дундговь аймгийн Төрийн сан банк дахь орон нутгийн төсвийн 100080000955 дугаар дансанд 2018 оны 3 дугаар сарын 25-ны дотор төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2018 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Говь-Угтаал сумын Соёлын төвийн төсвийн шууд захирагч М.Ганбуд, нягтлан бодогч Д.Мөнхдорж нарт хариуцуулав.


АКТЫГ

ТОГТООСОН¹:

АУДИТОР  Б.ГАНТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРХЛЭГЧ



М.ГАНБУД

НЯГТЛАН БОДОГЧ


Д.БИЛЭГСАЙХАН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.